



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2026 оны 02 сарын 13 өдөр

Дугаар А/32

Улаанбаатар хот

“D-LAB” платформыг нэвтрүүлэх тухай

Засгийн газрын агентлагийн агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгаль орчны шинжилгээний лабораторийн үйл ажиллагааг цахимжуулж, мэдээллийн нэгдсэн сан үүсгэх ухаалаг систем “D-LAB” платформыг 2026 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс үйл ажиллагаандаа ашиглахыг аймгуудын Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга нарт үүрэг болгосугай.

2. Систем ашиглалтын тасралтгүй ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг Технологи, инновацийн хэлтэс (Д.Батдорж), Байгаль орчин, хэмжил зүйн төв лаборатори (Б.Цацрал) -д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Уур амьсгалын өөрчлөлт, орчны шинжилгээний хэлтэс (Н.Галцог)-т тус тус даалгасугай.

ДАРГА

Э.БАТТУЛГА